



**МОН-ИТ БУЛИГААР ХК-ИЙН ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2020 он

## АГУУЛГА

<b>НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>1</b>
<b>ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>1</b>
<b>ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....</b>	<b>5</b>
<b>ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ .....</b>	<b>7</b>
<b>4.1. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж.....</b>	<b>7</b>
<b>4.2. Үйлдвэрийн түүхий эд, туслах материал.....</b>	<b>10</b>
<b>4.3. Химийн бодисын хэрэглээ.....</b>	<b>10</b>
<b>4.4. Үйлдвэрийн дэд бүтцийн хангамж .....</b>	<b>10</b>
<b>4.5. Хог хаягдал.....</b>	<b>11</b>
<b>ТАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....</b>	<b>12</b>

## 1. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Хүчин чадал, товч тодорхойлолт

Тус үйлдвэр нь хагас болон эцсийн боловсруулалт хийсэн бод, богийн арьс жилд 500,000 ширхэгийг боловсруулах буюу 1150 квадрат метр эцсийн боловсруулалт хийсэн арьс, шир, 2.2 сая богийн арьсыг гүн боловсруулах хүчин чадалтай. Одоогийн байдлаар үйлдвэрийн хүчин чадлынхаа 30 орчим хувийг ашиглаж байна. Үйлдвэр нь үйлдвэрлэлийн хэсэг шохой, идээлэх, хатаах, гүйцэтгэх гэсэн цехүүдтэй. Арьс ширийг бүрэн боловсруулах үеийн хатаах, гүйцэтгэх цехэд тавигдсан тоног төхөөрөмжүүд нь олон улсын арьс ширний үйлдвэрийн салбарт хамгийн сүүлийн үед ашиглагдаж буй дэвшилтэт техник технологи бүхий “BILLERI”, “OMACA”, “INCOMA”, “CARLESSI”, “FLAMAR”, “SEMATA”, “MOSTARDINI” зэрэг фирмийн 50 машин, тоног төхөөрөмжүүдтэй. Мөн бэлэн болсон арьсны талбайн хэмжээг электроник болон гэрлийн тусгалын аргаар тодорхойлж холбогдох тооцоог хийдэг электрон хэмжих машин ажиллаж байна.

Бид орчин үеийн шийдэлтэй, ажилтны эрүүл мэнд, тав тухыг хангасан оффис, үйлдвэрийн байрыг ашиглалтад оруулсан, дотоодын болон гадаадын хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн чанартай арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн. Цахилгаан, сантехник, уурын шугам хоолойн иж бүрэн шинэчлэлт, ялтсан дулаан солилцуурын системийг суурилуулсан. Чадварлаг ажилтнуудыг бэлтгэхийн тулд гадаад мэргэжилтнүүдийг урьж ажлын байран дээр сургалт явуулсан. Гадаадад үйлдвэрлэлийн дадлага хийлгэх зэрэг ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна. Бидний зүгээс дотоодын арьс шир боловсруулах үйлдвэрүүд, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай нэн тэргүүнд хамтран ажиллахыг зорилго болгон ажиллаж байна. Үүний дүнд цэвэр технологид суурилсан, тогтвортой үйлдвэрлэл, түүхий эдийн хаягдлыг бууруулах, мэргэжлийн лаборатори, мэдээлэл судалгааны төв байгуулах, дэлхийн зах зээлд өрсөлдөх, чанартай арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нээгдэх юм. Мон-ит булигаар ХК-д үйлдвэрлэсэн арьсаар МУ-ын бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд таатай боломжийг олгож байна.

#### Стратегийн зорилт / Хүлээгдэх үр дүн

- ✓ Гадаад экспорт нэмэгдүүлэх, импортыг орлох
- ✓ Дотооддоо ажлын байр нэмэх
- ✓ Дотоодын бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хэрэгцээг чанарын өндөр түвшинд боловсруулсан арьсаар хангах
- ✓ Арьс ширний салбарын хөгжилд хувь нэмэр оруулан, технологийн өөрчлөлт, шинэчлэл, сайжруулалтыг байнга хийн гүйцэтгэхийг зорих

### ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын анхны арьс шир боловсруулах үйлдвэр болох “Мон-Ит Булигаар” ХК нь 1934 байгуулагдаж одоогийн үйлдвэр нь 1976 онд БНСЧУ-ын техник эдийн засгийн тусламжаар жилд 375 мянган бодын шир үйлдвэрлэх зориулалттайгаар ашиглалтад орсон юм. Улмаар 1995-1998 онуудад техник, технологийн иж бүрэн шинэчлэлт хийн жилд 500 мянган бодын шир гүйцэт боловсруулах буюу 1,150 мянган квадрат метр эцсийн боловсруулалт хийсэн арьс шир болон 2,2 сая богийн арьс гүн боловсруулалт хийхээр 1998 оны 12-р сард ашиглалтад орсон. 2009 онд бүх гишүүдийн хурлаар “Мон-Ит Булигаар” ХК нэртэй болсон.

1934 оны 3 сарын 26-ны өдөр Аж үйлдвэрийн комбинатыг анх ашиглалтад оруулжээ. Энэ комбинатын бүрэлдэхүүнд шохойдох, идээлэх, гүйцэтгэх цехтэй булигаар боловсруулах хүчин чадалтай Булигаарын завод, Арьс дээлийн завод, Гутлын фабрик тус тус багтаж байв. Ингэж манай орны үндэсний үйлдвэрлэлийн анхны суурь тавигдсан түүхтэй. Өнгөрсөн 80 жилийн хугацаанд технологийн дэвшил, улс орны хөгжлийг дагаж үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалт, технологийн дэвшил, улс орны хөгжлийг дагаж үйлдвэрлэлийн бүтэц, зохион байгуулалт, технологийн дамжлагын хувьд өөрчлөгдсөн шинэчлэгдэж ирсэн байна.

Монголын хөнгөн аж үйлдвэрийн анхны үйлдвэрийн нэг болох Булигаарын завод 1976 онд БНСЧСУ-ын техникийн туслалцаатайгаар бүрэн шинэчлэгдэж, 1998 онд Итали улсын зээлээр бүрэн шинэчлэл хийж хагас болон эцсийн боловсруулалт хийсэн бод, богийн арьсыг Европ болон дотоодын зах зээлд нийлүүлдэг бөгөөд жилд 500,000 бодын шир гүйцэт боловсруулах буюу 1150 квадрат метр эцсийн боловсруулалт хийсэн арьс шир, 2.2 сая богийн арьсыг гүн боловсруулах хүчин чадалтай ажиллаж байна. Одоогийн байдлаар үйлдвэрийн хүчин чадлынхаа 30 орчим хувийг ашиглаж байна. Компани нь нийт 60 ажилтнуудтай арьс ширний салбарын тэргүүлэгч компанийн нэг юм. Ажилтнуудын 60 гаруй хувь нь мэргэжлээрээ 10 гаруй жил ажилласан тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Анх 1991 онд их хувьчлалаар Булигаар ХК нь нэг бүрийн үнэ нь 100 төгрөгийн үнэтэй 260,000 хувьцаа гарган 26,000,000 төгрөгөөр өөрийн үйлдвэрийн байраа үндсэн хөрөнгөөр үнэлж хувьчлагдаж байсан. Батмонгол ХХК нь 32 хувийг худалдан авч 1995-1998 онуудад техник, технологийн иж бүрэн шинэчлэлт хийн 1998 онд ашиглалтад ороход 260,000-аад хувьцаа нэмж гаргасан ба тухайн үед Итали Монгол хоёр улсын хоорондын гэрээгээр 17 сая ам.долларын зээл Мон-Ит Булигаар ХК нь Монгол Банкны батлан даалтаар авч, 2005 он гэхэд энэ өр төлбөр төлөгдөж дуусч байв. Тус арилжааны зээл нь Италийн засгийн газрын томилсон даатгалын компаниар даатгагдаж, үйлдвэрлэсэн арьс шир болон бүтээгдэхүүнээ Итали улс руу нийлүүлэх замаар төлбөр гүйцэтгэх нөхцөлтэй байсан ба зээлийн 2.5 сая ам.долларыг Үйлдвэрийн хувь нийлүүлсэн банкаар санхүүжиж Мон-Ит Булигаар ХК гаргасан. Тухайн үед компанийн бүтэц зохион байгуулалт нь нойтон цех 100 гаруй ажилтантай (шохойн тасаг, идээлэгийн тасаг 2 ээлжтэйгээр), хатаах цех 2 ээлжтэй нийт 40 гаруй ажилтантай, гүйцэтгэх цех мөн 40 гаруй ажилтны бүрдэлтэйгээр 3-н цех ажиллаж, технологич инженерийн нийт 10 гаруй хүмүүсийн бүрдэлтэй, засварын 18, сан техникийн 5 орчим ажилтны бүрдэлтэй ажиллаж байв.

Өдрийн үхрийн шир боловсруулах хүчин чадал 2000, гарцын хувьд зах зээлд шилжсэний дараа өдрийн 500 гаруй үхрийн арьс бүтэн, 3000 хонины арьс хагас боловсруулж байв. Социализмийн үед 1.8 га газартай байсан. 2008 он хүртэл Мон-Ит Булигаар ХК-ийн хяналтын багцыг Италичууд эзэмшдэг байсан ба сүүлийн 10 жил үйл ажиллагаа зогсонги, дампуурлыг ирмэг дээр байсан бол эдүгээ 100% дотоодын компани болж, арьс ширний салбарт 28-н жилийн туршлагатай баг хамт олноор удирдуулан үйл ажиллагааг сэргээн явуулах боломжтой болж буй юм.

Тус компани нь бод, богийн арьсыг хагас болон гүйцэт боловсруулан вэт-блю, краст, булигаар, гялгар хром, артай хар хром, гутлын дотор зэргийг үйлдвэрлэн дотоод болон гадаадын зах зээлд борлуулдаг бөгөөд үндсэн хэрэглэгчид нь Монгол улсын гутлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд юм. Боловсруулсан гутлын арьсыг нийлүүлэхэд одоогийн байдлаар 30 гаруй гутлын болон жижиг эдлэлийн үйлдвэрлэгч нарт нийлүүлж байна.

2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийг шинээр томилж, ТУЗ байгуулагдсанаас хойш 5 сарын хугацаанд үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн менежментийн шинэчлэлд томоохон хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс:

- ✓ Барилга байгууламжийн засвар үйлчилгээнд 1,2 тэрбум төгрөг
  - ✓ Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 224 сая төгрөг
- Нийт: 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.**



*Зураг 1. Үндсэн барилга байгууламж*

Тус компанийн үндсэн барилга байгууламж нь 1976 онд баригдсан бөгөөд технологийн тоног төхөөрөмж болон инженерийн шугам сүлжээний хувьд бүрэн шинэчлэгдсэн тул тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.



Зураг 2. Үйлдвэрийн дотоод зохион байгуулалт

Гадна инженерийн шугам хоолойг бүрэн шинэчилж 219мм-ийн голчтой 250 метр шугам, 89мм-ийн голчтой 130 метр шугам хоолой болон хучилтын бетон хавтангуудыг тус тус шинээр сольсон. Үйлдвэрийн дулаан хангамж, хэрэглээний халуун усыг тэжээх хүчин чадалтай 2 ширхэг ялтаст дулаан солилцуурыг иж бүрнээр нь суурилуулснаар уур, ус, дулааны зардлаа хэмнэх, мөн түүнчлэн ажилтнууд дулаахан тав тухтай орчинд ажиллах боломжтой болсон. Цэвэр, бохир ус, халаалтын шугам хоолой, халаагуурыг бүрэн шинэчилж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн өрөөний тоноглолуудыг суурилуулсан.

Зураг 3. Дулааны шугам сүлжээг иж бүрэн сольсон



Үйлдвэрийн барилгын 7200 м<sup>2</sup> дээврийг бүрэн хуулж, шинээр цутгалт хийж ус чийгийг тусгаарлах PVC мембран дээвэр хийсэн. Үйлдвэрийн барилгын гадна фасадны 1700м<sup>2</sup> талбайг хөөсөн хавтангаар бүрж дулаалсан. Үйлдвэрийн барилгын 500 ширхэг цонхыг шинээр сольсон.



*Зураг 4. Барилга байгууламж засварлаж, ашиглалтад оруулав.*

Барилгын 6-р давхрын 2200м<sup>2</sup> талбайг орчин үеийн стандартыг хангасан оффис болон үйлдвэрлэлийн зориулалтаар бүрэн засварлаж ашиглалтад оруулсан. Барилгын 2-р давхрын 900м<sup>2</sup> талбайг оффисийн зориулалтаар засварлаж, ажилтнуудын тав тухыг бүрэн хангасан тавилга, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон оффисийн өрөөнүүд, хурал болон сургалтын өрөө, цай кофений хэсэгтэй, тааламжтай орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Барилгын 1-р давхрын 900м<sup>2</sup> талбайг нэг ээлжиндээ 150-200 хүн хооллох хүчин чадал бүхий ажилтнуудын цайны газар, стандартын шаардлага хангасан хуурай хүнс хадгалах агуулах, VIP хоолны танхим, бэлэн бүтээгдэхүүн борлуулах дэлгүүрийн зориулалтаар иж бүрэн засаж тохижуулан ашиглалтад оруулав. Хятад улсын HSEE брэндийн 1000кг даац бүхий зорчигчийн лифтийг шинээр суурилуулж, ашиглалтад оруулав.

## **ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

“Мон-Ит Булигаар” ХК нь бүтэц зохион байгуулалтын хувьд үйлдвэрлэл, санхүү, маркетинг, борлуулалт болон гадаад худалдаа, захиргааны гэсэн хэсгээс бүрддэг. Үйлдвэрлэлийн хэсэг шохой, идээлэх, хатаах, гүйцэтгэх гэсэн нойтон, хуурай, гүйцэтгэх цехүүдтэй.



Тус компани нь 60 ажилтнуудтай, үүний дотор мэргэжлийн инженер техникийн ажилтан 8, эдийн засаг, санхүү, хүний нөөц, маркетингийн мэргэжилтэн 6, тоног төхөөрөмжийн мэргэжлийн ажилтан 3, технологийн мэргэжлийн ажилтан 33 хүн тус тус ажиллаж байна.

Инженер техникийн ажилтнууд Турк улс болон хөгжилтэй орнуудад үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Нийт ажилтнуудын 60 гаруй хувь нь мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан ажилтан байдаг.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн Арьс ширний үйлдвэрлэлийг дэмжих төсөл болон бусад олон улсын байгууллагууд ба өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан арьсны боловсруулалтыг процесс болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулахын тулд Итали, Герман, Испани улсын мэргэжлийн гадаад зөвлөх авч ажилласан бөгөөд үүний үр дүнд арьсны чанар сайжирч, ашиглалтын талбай нэмэгдэж, бүтээгдэхүүний төрлийг олшруулж чадсанаар хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээг хангах чадвартай болсон. Эдгээр нь борлуулалтад эерэгээр нөлөөлж байгаа болно.

Тус компанийн арьс шир боловсруулах үйлдвэрлэл нь нойтон болон хуурай боловсруулалтын 25 технологийн дамжлагатай. Боловсруулалтын нэг өдрийн оролт нь 1500-2000 үхрийн шир бөгөөд технологийн цикл нь зундаа 21 хоног, өвөлдөө 25 хоног байдаг.

Боловсруулалтад Испани улсын химийн бодисыг хэрэглэх бөгөөд ингэснээр чанартай бүтээгдэхүүн хийхийн тулд технологийн сахилгыг чанд мөрдөн ажиллана. Арьс ширний салбарт олон жил ажилласан туршлагатай инженер, технологич, технологийн мэргэжлийн ажилтнуудтай тул технологийн горим мөрдөх, үйлдвэрлэлийн дамжлагын хяналтыг тогтоох зарчмыг чанд мөрдөн ажилладаг.



## ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ

### 4.1. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

Арьс ширийг бүрэн боловсруулах зориулалттай хатаах, гүйцэтгэх цехэд тавигдсан тоног төхөөрөмжүүд нь олон улсын арьс ширний үйлдвэрийн салбарт хамгийн сүүлийн үед ашиглагдаж буй дэвшилтэт техник технологи бүхий “BILLERI”, “OMACA”, “INCOMA”, “CARLESSI”, “FLAMAR”, “CEMATA”, “MOSTARDINI” зэрэг фирмийн 50 машин, тоног төхөөрөмжүүдтэй. Мөн бэлэн болсон арьсны талбайн хэмжээг электроник болон гэрлийн тусгалын аргаар тодорхойлж холбогдох тооцоог хийдэг электрон хэмжих машин ажиллаж байна.

Химийн боловсруулах цех тоног төхөөрөмжийн хүчин чадлаараа ажиллахад нэг өдөрт:

Үхэр – 800 ширхэг, Хонь – 3500 ширхэг арьсыг ветблю болгох буюу  
 Үхэр – 240 ширхэг, Хонь – 1000 ширхэг ветблю арьсыг суурь будаг хийж тосолж бэлэн болгоно.

Химийн боловсруулах цехэд Африкийн хатуу улаан модыг тосонд чанаж хийсэн, 2 мм-ийн гуулин ялтсаар доторлосон идээлэх, зумлах, шохойдлого, будгийн зэрэг зориулалттай маш сайн чанарын 26 барабанаас гадна арьс шир махлах, хуваах, хусах, шахах, индүүдэх, хэмжих машинууд ажиллаж байна.

Хатаах, гүйцэтгэх цех нь тус бүртээ өдөрт үхэр 300-350 ширхэг, хонь 1000-1200 ширхэгийг бэлэн болгож гаргана. Арьс ширийг бүрэн боловсруулах үеийн хатаах, гүйцэтгэх цехэд тавигдсан тоног төхөөрөмжүүд нь олон улсын арьс ширний үйлдвэрийн салбарт хамгийн сүүлийн үед ашиглагдаж буй дэвшилтэт техник технологи юм. Тухайлбал арьсыг 4-6 минутанд вакуумын аргаар хатаах вакуум хатаалга, арьсны чийг хатаалтын түвшинг автоматаар тохируулагч гинжин хатаалгууд, арьсны харьцангуй суналт, даалтын хэмжээг хэрэглээнд тохируулж хатаагч раман хатаалгууд тавигдсан юм. Хөрсөндөө гэмтэлтэй арьс ширний гэмтлийг арилгах зориулалт бүхий арьсны өнгө зүлгэх агрегатууд тавигдсан бөгөөд арьсны хучих будгийг 2 төрлийн аргаар /тухайлбал түрхэх, шүрших/ будах тоног төхөөрөмжүүд ажиллаж байна. Боловсруулсан арьсны өнгийг сайжруулах 3 төрлийн арлах, хээлэх, пресслэх, өнгөлөх машинууд тавигдсан. Бэлэн болсон арьсны талбайн хэмжээг электроник болон гэрлийн тусгалын аргаар тодорхойлж холбогдох тооцоог хийдэг электрон хэмжих машин ажиллаж байна

Тус үйлдвэрийн нийт тоног төхөөрөмж нь 1998 онд шинээр суурилагдсан. Итали, Чех улсад үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүд бөгөөд дэлгэрэнгүй жагсаалтыг дараах хүснэгтээс үзнэ үү.

**Хүснэгт 1. Үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал, арьс шир/8 цаг	Үйлдвэрлэсэн улс	Үнэлгээ
1.	Барабанууд	6000 ш бог, 900 ш бод	Итали	сайн
2.	Будгийн ёмкость 450 л		Итали	сайн
3.	Шахах машин GJ3A	400 ш	Итали	дунд
4.	Шахах машин 2700 мм	800 ш	Хятад	дунд
5.	Шахах машин	400 ш	Итали	дунд
6.	Хусах машин /2/	300 ш	Итали Чех	дунд
7.	Хусах машин 1700 мм	700 ш	Итали	дунд

8.	Хусах машин	600 ш	Чех	дунд
9.	Хуваах машин 2100	600 ш	Итали	сайн
10.	Хуваах машин	600 ш	Итали	сайн
11.	Махлах машин /хонины/	1400 ш	Чех	дунд
12.	Махлах машин /үхрийн/	500 ш	Чех	дунд
13.	Лабораторийн тоног төхөөрөмж	20 гаруй тоног төхөөрөмж	Итали	дунд
14.	Индүү машин 2700 мм	500 ш	Итали	дунд
15.	Хувиарлах ёмкост 600 л		Итали	сайн
16.	Зоргодос дамжуулах шугам		Итали	дунд
17.	Гүүрэн кран		Чех	сайн
18.	Ачааны лифт		Орос	дунд
19.	Бохир агаар цэвэрлэх систем		Итали	сайн
20.	Барабаны ус хэмжих шугам		Итали	сайн
21.	Арьс хэмжих машин	1400 ш	Хятад	сайн
22.	Арьс голоо зүсдэг машин	600 ш	Итали	дунд
23.	Акумлятор цэнэглэгч		Итали	дунд
24.	Агааржуулалт систем		Итали	дунд
25.	Чөлөөт хатаалга	600 ш	Итали	сайн
26.	Тэлдэг хатаалга	450 ш	Итали	сайн
27.	Тосолгооны машин		Итали	сайн
28.	Тоос цуглуулагч систем		Итали	сайн
29.	Зүлгэх машин	100 ш	Итали	сайн
30.	Өнгө зүлгэх машин	500 ш	Итали	сайн
31.	PALISSONE VERTICALE FICINI-EU зөөлрүүлэх машин	300 ш бог	Итали	сайн
32.	PALISSONE VERTICALE FICINI зөөлрүүлэх машин	300 ш бог	Итали	сайн
33.	Molisse	448 ш	Чех	дунд
34.	Incoma Вакум хатаалга	825	Итали	дунд
35.	Fimet талхих барабан	300 ш	Итали	сайн
36.	Carlessi усалгааны машин	780 ш	Итали	сайн
37.	Электрон хэмжих машин	1000 ш	Итали	сайн
38.	Шүрших машин	1000 ш	Итали	сайн
39.	Хатаагч дамжуулагч	575 ш	Итали	сайн
40.	Гар шүрших	50 ш	Итали	сайн
41.	Өнгөлөгч машин	100 ш	Итали	сайн
42.	Mostardini ротар арлах	1000 ш	Итали	сайн
43.	Mostardini арлах маш	550 ш	Итали	сайн
44.	Gemata машин суурь будгийн агрегат	575 ш	Итали	сайн
45.	Пүү 15 кг		Итали	дунд
46.	Пүү 2000 кг		Итали	дунд
47.	Хими станц	9 тоног төхөөрөмж	Итали	сайн
48.	Ус хувиарлах станц		Итали	сайн
49.	Поо		Итали	дунд
50.	Цахилгаан тэргэнцэр		Итали	дунд

## Үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлт, тоног төхөөрөмжийг сайжруулах талаар:

Химийн боловсруулах цехийн 26 ширхэг барабан дээр бүрэн автоматжуулалт хийгдсэн. Шохойн 8 барабан, хромын 10 барабан дээр 3 ширхэг холигч системийг иж бүрнээр нь шинэчилсэн. Химийн боловсруулах цехийн дулаан хангамжийг сайжруулах зорилгоор 20 ширхэг VOLCANO төхөөрөмжийг суурилуулсан. Химийн боловсруулах цехийн цэвэр ус, халуун ус, дулааны 950 метр шугамыг иж бүрэн сольсон.



Зураг 5. Тоног төхөөрөмжүүдийг засварлаж, шинэчилсэн.

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж махлах болон шахах сунгах машиныг тус бүрийг шинээр суурилуулж өгснөөр өдөрт 300 ширхэг бодын шир, 1000 ширхэг богийн арьс нэмэлтээр боловсруулах боломжтой болсон. Гүүрэн краны механик эд ангиудыг шинэчилж, PLC төхөөрөмжөөр тоноглогдсон инвектор удирдлагатай цахилгаан хөдөлгүүртэй болгож бүрэн автоматжуулсан, электрон жин суурилуулснаар ачааны даац хэтрэлтийг бүрэн хянаж, аюулгүй өргөлт хийх боломжтой болсон.

#### 4.2. Үйлдвэрийн түүхий эд, туслах материал

Компани нь түүхий эд бэлтгэлийн компани өөрөө түүхий эдийн зах дээрээс худалдан авах, түүхий эд бэлтгэх агентуудтай гэрээ хийж үйлдвэр дээрээ хүлээн авах гэсэн үндсэн 2 системийг ашигладаг. Түүхий эд бэлтгэх гэрээт агентуудаас үйлдвэр дээр хүлээн авах хэлбэрээр зохион байгуулж байна. Энэхүү хэлбэр нь үйлдвэрийн хувьд цаашид илүү чанартай түүхий эдийг зардал багатайгаар төлөвлөсөн цаг хугацаандаа бэлтгэх боломжийг илүү хангаж байна.

#### 4.3. Химийн бодисын хэрэглээ

“Мон-Ит Булигаар” ХК нь үйлдвэрлэлдээ ашигладаг химийн бодисуудаа Олон улсын чанарын гэрчилгээтэй, дэлхийн нэр хүндтэй компаниуд болох Испанийн Cromogenia, Франц улсын АТС, Хятадын Фанбо зэрэг компаниудаас шууд гэрээлэн импортлодог бөгөөд эдгээр материалууд нь дэлхийн стандартад нийцсэн чанарын баталгаатай байдаг. Боловсруулах үйлдвэрт 35 нэр төрлийн бодис ашигладаг.

#### 4.4. Үйлдвэрийн дэд бүтцийн хангамж

**Цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэр:** Тус үйлдвэр нь УБ хотын “Нолго” ХХК-тай гэрээ байгуулан, 1 талын тэжээлтэй, 1-р зэргийн хэрэглэгч болж, цахилгааныхаа хэрэглээгээ хангадаг. УБ хотын Дулааны шугам сүлжээнээс жил тутам хийгдсэн гэрээний дагуу дулаанаар хангадаг.

**Усан хангамжийн эх үүсвэр:** “Мон-Ит Булигаар” ХК нь МУ-ын Иргэний тухай хууль, Усны тухай хуулийн 16, 17, 19, 20, 22, 28-р зүйл, “Хот суурины усан хангамжийн ашиглалтын тухай хууль”, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1996 оны 3-р сарын 12-ны өдрийн 62 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр ус түгээгүүр, ариутгах татуургыг ашиглах дүрэм”-ийг тус тус үндэслэн УБ хотын УСУГазартай гэрээ байгуулан усан хангамж, ариутгах татуургын сүлжээнээс цэвэр ус авч, үйлдвэрийн бохир усыг Ус Сувгийн Удирдах Газрын харьяа Урьдчилан цэвэрлэх байгууламжийн албаны ариутгах татуургын сүлжээнд цэвэршүүлэхээр нийлүүлж байна. Эдгээр ашиглалт нь УСУГазар, мэргэжлийн хяналт зэрэг газраар хянагдан, зохицуулагдаж байдаг байна.

**Ус ашиглалтын төрөл, хэмжээ:** Тус компанийн усны хэрэглээнд арьс, нэхий боловсруулалт, тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээ, ажилтнуудын унд, ахуйн хэрэглээний ус багтах бөгөөд тус бүрд хэрэглээг тооцон доор үзүүлэв.

**Хүснэгт 2. Нийт усны хэрэглээ**

№	Усны зориулалт	Өдөр /м <sup>3</sup>	Сар /м <sup>3</sup>	Жил /м <sup>3</sup>
1.	Нийт технологийн зориулалтын ус	151.7	4 550.8	54 610.1
2.	Техникийн усны хэрэглээ	1	30	365.0
3.	Унд ахуйн хэрэглээ	13.2	396.0	4 752.0
4.	Цэцэрлэгжүүлэлт усалгаа	1.5	6.0	24.0
5.	Тоосжилт, замын суурь нягтаршуулах	1.64	14.0	84.3
	<b>Цэвэр усны хэрэглээ</b>	<b>169.04</b>	<b>4 996.8</b>	<b>59 835.4</b>

**4.5. Хог хаягдал**

**Хатуу хог хаягдал:** Тус компанийн хэмжээнд ахуйн хуурай хог хаягдал жилд дунджаар 8.4 тн гардаг бөгөөд хогийн хэмжээнээс шалтгаалан Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тэй байгуулсан “Хан-Уул дүүргийн аж ахуйн нэгж албан байгууллагын хог хаягдлыг ачиж тээвэрлэх” гэрээний дагуу хаяж зайлуулдаг байна.

**Шингэн хог хаягдал:** Арьс, шир боловсруулах үйлдвэр нь Хан-Уул дүүргийн 2-р хороо, Үйлдвэрийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар хотын төвийн системийн цэвэр ус, дулаан, бохирын шугамд холбогдсон тул тухайн бохир ус шууд зайлуулагддаг.

Харин арьс шир боловсруулагдах үйлдвэрийн технологи үйл ажиллагаанаас гарсан хаягдал бохир усыг Ус Сувгийн Удирдах Газрын харьяа Урьдчилан цэвэрлэх байгууламжтай “Технологийн хаягдал усыг татан зайлуулж, урьдчилан цэвэрлэх” №102514 тоот гэрээг 2017 оны 1 дүгээр сарын 14-ны өдөр байгуулсан байна.

Гэрээнд УСУГ харьяа УЦБ-д бохир усаа нийлүүлж буй хэрэглэгчийн үйлдвэрийн технологиос гарсан зөвшөөрөгдсөн хэмжээний бохирдолтой усыг хүлээн авч механик болон химийн урьдчилсан цэвэрлэгээ хийж төв шугамд нийлүүлэх, урьдчилан цэвэрлэх байгууламжийн технологи үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахаар тусгажээ.

**“МОН-ИТ БУЛИГААР” ХК-ИЙН 2020 ОНЫ II УЛИРЛЫН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**САНХҮҮ БАЙДЛЫН ТАЛААР:**

Тайлант улиралд нийт борлуулалтыг 562.9 сая төгрөгөөр борлуулалт хийж гүйцэтгэсэн.

Үзүүлэлт	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт зардал</b>	338,288.8		
<b>Нийт орлого</b>	562,893.4		
<b>Санхүүжилт</b>			
<b>Нийт ашиг/алдагдал</b>	224,604.60		

**1. Борлуулалт:**

**А. Үндсэн үйл ажиллагаанаас 562.9сая төгрөгийн борлуулалт хийсэн. /сая.төг/**

№	Бүтээгдэхүүн	Тоо хэмжээ	Гүйцэтгэл
<b>1</b>	Хром	3,583.00	74.65
<b>2</b>	Булигаар	1631	59.43
<b>3</b>	Үстэй шир	13	3.20
<b>4</b>	Хонь	1131	5.32
<b>5</b>	Ямаа	329	4.91
<b>6</b>	Цүнх жижиг эдлэл	2560	112.48
<b>7</b>	Боловсруулалтын орлого		298.30
<b>Үндсэн бус үйл ажиллагааны орлого</b>			
<b>1</b>	Бусад орлого		4.6

**2. Зардлын талаар:**

№	Зардлынтөрөл	2-р улирал		Зөрүү	
		төлөв	гүйц		
1	Цалин		373.0		
2	НДШимтгэл		26.3		
<b>ДҮН</b>					
3	Борлуулсан бүтээгдэхүүн		338.29		
8	Мэргэжлийн үйлчилгээний зардал		7,8		
9	Харуулхамгааллын зардал		13.2		
10	Холбоо		3.4		
11	Бичиг хэрэг		6.4		
12	Албан томилолт		0.46		
13	ҮХ-н элэгдэл				
14	Хөдөлмөр хамгаалал		3.9		
15	Шатахуун түлш, тос		5.7		
16	Ашиглалтын зардал		2.8		
17	Цэвэрлэгээ		3.2		
27	Дулааны зардал		13.7		
28	Усны зардал		5.1		
29	Зээлийн хүүгийн зардал		273.0		
30	Бусад зардал		52.68		
<b>Нийт зардлын дүн</b>					

**3. Авлагын талаар: /сая.төг/**

№	Авлагын төрөл	2019.12.31	2020.06.30	Өсөлт бууралт(+/-)
1	ААНэгж	1770.3	1420.3	19.7

**4. Өглөгийн талаар:**

	Өглөг	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
Хуримтлагдсан	Татвар	411.6	500.1	88.5
	НДШ	175.1	243.7	68.6
	Цахилгаан	536.8	438.6	-98.2
	ДДЦС	209.2	209.2	0.0
	<b>Дүн</b>	<b>1,332.7</b>	<b>1,391.6</b>	<b>58.9</b>
	Бусад өглөг	123.1	47.5	-75.6
	Богинохугацаатзээл	138.4	89.7	-48.7
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,594.2</b>	<b>1,528.8</b>	<b>-65.4</b>